



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№86 /299/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.05.04

Цаг үе, үйл явдал

“ЦЭРГИЙН ОЛИМП” ГАРААНААС ГАРЛАА



Зэвсэгт хүчний 2022 оны марш-тусгай бэлтгэлийн аварга салаа, тасаг, цэргийн мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээний нээлтийн ажиллагаа өнөөдөр Таван толгой дахь Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулагдлаа.

Нээлтийн ажиллагаанд батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, БХЯ-ны ТЗУГ-ын дарга хурандаа С.Ванчинхүү, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг болон ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын удирдлага, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн захирагч, нар тэмцээний шүүгчид оролцлоо.

Цэргийн алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, авхаалж самбаа, тэсвэр хатуужлыг сорьсон Зэвсэгт хүчний марш-тактик тусгай бэлтгэлийн аварга салаа, тасаг шалгаруулах тэмцээнд байнгын бүрэлдэхүүний 2 рот, 15 салаа, хугацаат цэргийн алба хаагчдын 16 салаа, эмэгтэй цэргийн алба хаагчдын 17 тасаг, нийт Зэвсэгт хүчний 33 нэгтгэл, ангийн 1500 гаруй цэргийн алба хаагч оролцохоор бэлтгэл, сургуультай хангаж, Таван толгойдахь Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд жигдрэн жагсаад байна. Зэвсэгт хүчний марш-тусгай бэлтгэлийн аварга салаа, тасаг, оны мэргэжлийн аварга офицер, ахлагч, шалгаруулах тэмцээн нь жилээс жилд хурц ширүүн өрсөлдөөнтэй, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын цэргийн сургалт бэлтгэлийн чанар, үр дүнг бодитоор илтгэн харуулдаг

томоохон сорилт, шалгуур болдог. Үүнээс гадна Зэвсэгт хүчний бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх, цэргийн алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилт, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, тэсвэр хатуужил, зөв хүмүүжил, төлөвшил, эерэг хандлага олгох зорилготой энэхүү тэмцээнээр дамжуулан иргэд, олон нийтэд цэргийн хөдөлмөрийн онцлог, ач холбогдлыг сурталчлан таниулах, цэргийн насны залууст алба хаах итгэл үнэмшил, урам зориг өгөх чухал ач холбогдолтой тэмцээн юм.

Энэ жилийн тэмцээн нь эзлэгдсэн объектыг чөлөөлөх, гранат шидэх, буудлагын шинэ төхөөрөмжүүдийг ашиглах зэрэг өөрчлөлтүүдээр хүрээгээ тэлснээр онцлогтой дээр Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн командлалуудыг шинээр байгуулж, бие даасан ажиллагааг нь хангах, үүрэг гүйцэтгэх боломж, чадварыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байгаа нь энэхүү тэмцээнийг илүү, сонирхолтой, өрсөлдөөнтэй болгож байгаа талаар ЗХЖШ-ын дарга дурдсан юм.

Түүнчлэн энэ удаагийн тэмцээнд амжилттай оролцсон баг, тамирчид 2007 оноос уламжлал болон явагдаж буй Төрийн цэргийн байгууллагуудын дунд явагдах марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээнд Зэвсэгт хүчнээ төлөөлөн оролцох хариуцлагатай үүргийг хүлээх юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 14	☁️ -3


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,100.00	3,115.0
EUR 🇪🇺	3,325.0	3,345.0
CNY 🇨🇳	470.00	472.00
RUB 🇷🇺	38.60	39.00
JPY 🇯🇵	24.00	24.80
KRW 🇰🇷	2.45	2.49

ЗУРХАЙ



2022.05.04 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 4

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН
МОГОЙ САРЫН ТАВАН
ШАР МЭНГЭТЭЙ УЛААГЧИН
МОГОЙ ӨДӨР**

Үс засуулбал:
Бие эрхтний хүч сайжирна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.30-20.08
Барилдлага:
Үл зохилдох
Шүтэн барилдлага:
Хурьцахуй
Суудал: Шороо

Энэ өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие эрхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,273,004 /69.9%!	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,175,662 /66.9%!	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,040,412 32,0% 125,447 /3,9%!
НИЙТ БАТЛАГДСАН 8470 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 11	ЭДГЭРСЭН 8338

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 514,685,574

Эдгэрсэн

Нийт: 469,373,966

Нас барсан

Нийт: 6,265,896

БАГА НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ
ТА БҮХЭН ХҮҮХЭДЭЭ ЭРТ ИЛРҮҮЛЭГТ ХАМРАХЧЛААРАЙ!

0-5
НАС

ВСВТ ЛАГЖИЛТ

АМНЫ ХӨНДИЙН
ЭРҮҮЛ МӨНД

ЭМЧИЙН ҮЗЛЭГ

ВСӨЛТНИЙ
ҮНЭЛГЭЭ

ЗАН ТӨРХИЙН
ҮНЭЛГЭЭ



ШҮДИЙН ҮЗЛЭГ

ШҮД, УГААХ
АРГАЧЛАЛ

ЭРҮҮЛ АХУЙН
ЗӨВЛӨГӨ

Цахим шууданд

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫГ ХЭРХЭН ЯВУУЛАХ ТАЛААР СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9,46, 2021 оны 278 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг явуулах Батлан хамгаалахын сайдын тушаал өнгөрсөн сард гарч БХЯ, ЗХЖШ, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, БХЯ-ны харьяа байгууллагуудад хүргэгдээд байгаа билээ. Тус тушаалын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг хэрхэн явуулах сургалт зохион байгуулагдлаа. Сургалтад БХЯ, ЗХЖШ, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар Батлан хамгаалах яамны харьяа байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд хамрагдаж улсын үзлэг, тооллогын ажлын бэлтгэл хангах зөвлөмж, албан даалгавар хүргүүлэх тухай болоод тооллоготой холбоотой шийдвэр, журам, аргачлал, заавар, бусад холбогдох баримтыг хэрхэн бүрдүүлэх талаарх мэдээллийг авлаа. Мөн байгууллагын

эзэмшлийн газрын бүртгэл, барилга байгууламжийн хийц, хэмжээсийн бүртгэл, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, мал сүрэг, худаг суваг, оюуны өмчийн бүртгэл зэргийг хэрхэн явуулах талаар энд дэлгэрэнгүй дурдсан юм. Энэ удаагийн үзлэг, тооллогоор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтад байгаа эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хэмжээг тогтоох, хөрөнгийн чанар байдал, хадгалалт, хамгаалалт, үнэлгээ, бүртгэлд



үнэлэлт өгөх, төрийн өмчийн улсын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, улсын бүртгэлийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахаас гадна төрийн цахим мэдээллийн нэгдсэн сан "хур" системийн мэдээллийг ашиглах мэдээллийн нэгдсэн сангийн суурь программ хангамжийг ашиглах мэдээллийг цахимжуулахаас гадна төрийн мэдээллийн санд холбож, нийтэд нээлттэй цахим мэдээллийн санг бүрдүүлэх зорилго тавьжээ. Ташрамд яамны харьяа агентлаг, байгууллагуудын төрийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжил, арга зүйн дагуу зохион байгуулж нэгдсэн дүнг энэ оны 7 дугаар сарын 30-ны дотор Төв комисст хүргүүлсэн байх юм. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллоготой холбоотой бүхий л мэдээллийг Төрийн өмчийн зохицуулалтын газрын www.pcsr.gov.mn цахим хуудасны төрийн болон орон нутгийн өмчийн тооллого булангаас харж мэдээлэл авах боломжтой аж.

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗРЫНХАН ХАНДИВЫН АЯНД НЭГДЛЭЭ

Үрийнхээ төлөө тэмцэж яваа дэд хурандаа Б.Ууганбаяр, ахлагч С.Ганзаяа нарт эрхэм та туслаарай. Тус хэзээ ч багадаагүй юм шүү. Бяцхан охин нь тархины үрэвсэл өвчнөөр оношлогдож, БНСУ-д 450 сая төгрөгийн хагалгаанд яаралтай орох болсны дагуу аав, ээж нь болоод ЗХЖШ, ОБЕГ, Төрлийн цэргийн командлалууд хандивын аян өрнүүлж, сайхан сэтгэлт ард түмэн, мөрдэс нэгт нөхдөөсөө тусламжийн гараа сунгахыг уриалсаар байгаа билээ. Уриалгын дагуу зорим сайхан сэтгэлт түмэн олон, Зэвсэгт хүчин, Онцгой байдлын байгууллага, хамт олон хандивын аянд нэгдэж, тусламжийн гараа сунгаж байгаад офицер, ахлагчийнхаа



гэр бүлийн өмнөөс гүн талархал илэрхийлжээ. Өчигдөр буюу 5 дугаар сарын 03-ны өдөр хурандаа Х.Батсайхан даргатай Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын хамт

олон 1 сая төгрөг, хурандаа Б.Энхбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн хамт олон 2 сая 470 мянган төгрөгийг сэтгэлийн хандив илгээснээ гардуулж, бяцхан охиныг хурдан эдгэхийг өрөөлөө.

ХАНДИВ ИЛГЭЭСЭН САЙХАН СЭТГЭЛТ ХАМТ ОЛОН, ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨЛ:

1. Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал 2 сая 864 мянган төгрөг
2. Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлал- 2 сая 550 мянган төгрөг
3. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал- 1 сая 338 мянган төгрөг
4. Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар- 1 сая төгрөг
5. Зэвсэгт хүчний 084 дүгээр анги- 1 сая төгрөг
6. Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 085 дугаар салбар- 100 мянган төгрөг
7. Зэвсэгт хүчний 330 дугаар анги- 5 сая 430 мянган төгрөг
8. Зэвсэгт хүчний 331 дүгээр анги- 1 сая төгрөг
9. Онцгой байдлын 2013 оны онжавууд- 450 мянган төгрөг
10. БХИС-ийн 2003 оны Ерөнхий цэргийн Б курс- 300 мянган төгрөг
11. ДХИС-ийн Ахлагчийн сургуулийн онцгой байдлын сонсогч нар- 340 мянган төгрөг
12. БХИС-ийн 2005 оны төгсөгчид- 500 мянган төгрөг
13. Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл- 4 сая төгрөг
14. Зэвсэгт хүчний 338 дугаар анги- 1 сая 65 мянган төгрөг
15. Эсгий гутлын хамт олон- 1 сая 630 мянган төгрөг
16. НУБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн ажиллагч, штабын офицер нар- 5 сая 855 мянган төгрөг
17. Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар- 8 сая 600 мянган төгрөг
18. БНӨСУ-д явагдаж байгаа НУБ-ын энхийг сахиулах UNMISS ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн мотобудлагын батальон- 4250 ам.доллар буюу 13 сая 47 мянган төгрөг
19. Дархан-Уул аймаг, Буянхүү ахлагчтай "Amway" сүлжээний хамт олон- 400 мянган төгрөг
20. Зэвсэгт хүчний 123 дугаар анги- 2 сая 645 мянган төгрөг
21. Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэл- 600 мянган төгрөг
22. Зэвсэгт хүчний 284 дүгээр анги- 1 сая төгрөг
23. Зэвсэгт хүчний 011 дүгээр анги- 2 сая 910 мянган төгрөг
24. Зэвсэгт хүчний 017 дугаар анги- 1 сая 20 мянган төгрөг
25. Зэвсэгт хүчний Хяналт шинжилгээ, үнэлгээний газар- 480 мянган төгрөг
26. Зэвсэгт хүчний 119 дүгээр анги- 1 сая төгрөг
27. Зэвсэгт хүчний 336 дугаар анги- 3 сая төгрөг
28. ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтэс, цэргийн хүрээний цэргийн цагдаагийн бүрэлдэхүүн- 1 сая төгрөг
29. Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн 2009 оны ахлагч нар- 885 мянган төгрөг
30. Зэвсэгт хүчний 256 дугаар анги- 2 сая төгрөг
31. Зэвсэгт хүчний 337 дугаар анги- 1 сая 400 мянган төгрөг
32. Зэвсэгт хүчний 350 дугаар анги- 34 сая төгрөг
33. Зэвсэгт хүчний 167 дугаар анги- 1 сая төгрөг
34. Зэвсэгт хүчний 334 дүгээр анги- 1 сая төгрөг
35. Зэвсэгт хүчний 340 дүгээр анги- 1 сая 157 мянган төгрөг
36. Зэвсэгт хүчний 327 дугаар анги- 6 сая 630 мянган төгрөг
37. Зэвсэгт хүчний 120 дугаар анги- 915 мянган төгрөг
38. Сэлэнгэ аймгийн ОБГ- 1 сая 270 мянган төгрөг
39. 2001 оны артиллерийн курсын онжавууд- 600 мянган төгрөг
40. Comedy lab хамт олон- 1 сая 300 мянган төгрөг
41. ЗХЖШ-ын Санхүүгийн хэлтсийн хамт олон- 250 мянган төгрөг
42. Булган аймгийн Онцгой байдлын газар- 540 мянган төгрөг
43. Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн тусгай салбарууд нэгдэн- 3 сая 155 мянган төгрөг
44. Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар- 600 мянган төгрөг
45. Дорноговь аймгийн Онцгой байдлын газар- 1 сая төгрөг
46. Зэвсэгт хүчний 186 дугаар анги- 350 мянган төгрөг
47. Хэнтий аймгийн Онцгой байдлын газар- 1 сая төгрөг
48. Зэвсэгт хүчний 014 дүгээр анги- 1 сая 200 мянган төгрөг
49. Завхан аймгийн Онцгой байдлын газар- 640 мянган төгрөг
50. ОБЕГ-ын дэргэдэх Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр анги- 440 мянган төгрөг
51. Онцгой байдлын 179 дүгээр анги- 245 мянган төгрөг
52. Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газар- 600 мянган төгрөг
53. ОБЕГ-ын ар талын 115 дугаар анги- 500 мянган төгрөг
54. Өмнөговь аймгийн Онцгой байдлын газар- 1 сая төгрөг
55. ОБЕГ-ын харьяа Уул уурхайн аврах 09 дүгээр анги- 1 сая төгрөг
56. Төв аймгийн Онцгой байдлын газар- 865 мянган төгрөг
57. ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригад 257 мянган төгрөг
58. Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газар- 510 мянган төгрөг
59. ОБЕГ-ын дэргэдэх 112 дугаар анги- 140 мянган төгрөг
60. Архангай аймгийн Онцгой байдлын газар- 500 мянган төгрөг
61. Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газар- 500 мянган төгрөг
62. Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн хамт олон- 2 сая 470 мянган төгрөг
63. ОБЕГ-ын харьяа ДССЗТөв-113 дугаар анги- 450 мянган төгрөг
64. Зэвсэгт хүчний 015 дугаар анги- 1 сая 100 мянган төгрөг
65. Б.Баатар- 1 сая төгрөг
66. С.Удвал- 1 сая 100 мянган төгрөг
67. Б.Борхүү- 1 сая төгрөг
68. Багийн найз Наранбаатар- 1 сая төгрөг
69. Цэндсүрэнгийн гэр бүл -500 мянган төгрөг
70. ЗХЖШ-ын МАБ-ын дарга, хурандаа Ж.Хоролсүрэн гэр бүлийн хамт- 500 мянган төгрөг
71. Иргэн Даваагийн Мөнх-Эрдэнэ- 1 сая төгрөг
72. Иргэн Сэргэлэн- 500 мянган төгрөг
73. Л.Мөнхбаяр, Золжаргалын гэр бүлээс- 500 мянган төгрөг
74. Нинагийн гэр бүлээс -500 мянган төгрөг зэрэг халуун сэтгэлт олон нийт болон Зэвсэгт хүчин, Онцгой байдлын албаны хамт олноос туслаад байна.

ТӨРИЙН ТОРГОН ЦЭРГҮҮДИЙН ТӨРСӨН ӨДРИЙГ ДУРСАМЖ ДҮҮРЭН ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ



Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн "Сэтгэл зүйн хангалтын нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу хугацаат цэргийн алба хаагчдын "Төрсөн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх 04 дүгээр сарын арга хэмжээг "Хүндэт харуулын тусгай рот"-той хамтран өнөөдөр амжилттай зохион байгууллаа.

Арга хэмжээг нээж захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Г.Хатанбаатар хэлсэн үгэндээ "Төрийн торгон цэргийн ангид хугацаат цэргийн алба хаах хугацаанд төрсөн өдрөө мөр зэрэгцсэн дайчидтайгаа тэмдэглэн өнгөрүүлж байгаа нь та бүхний амьдралын

хуудсанд мартагдахааргүй дурсамж дүүрэн мөч болон үлдэх учиртайг онцлон хэллээ".

Баяр дээр баяр нэмж хүндэт зочноор ХХТР-ын дэд түрүүч М.Сугарсүрэнгийн

ээж Я.Хишгээ, ХУТР-ын дэд түрүүч С.Үйлстөгөлдөрийн ээж Д.Одгэрэл нар хүрэлцэн ирлээ. Төрсөн өдрийг тэмдэглэх үйл ажиллагаанд энгийн Мөнхбаясгалан, дэд түрүүч Д.Билгүүн, байлдагч Х.Алтанбагана нар "Заллага" дуугаар, байлдагч А.Энх-Амар, байлдагч Д.Лхагвасугар нар "Миний ээж" дуугаар, байлдагч Б.Жигмид "I m man" дуугаар, дэд түрүүч Д.Билгүүн, байлдагч Х.Алтанбагана нар "Байлдагчийн дуу"-аар тус тус ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

Ахлах дэслэгч Т.ДЭЛГЭРМАА



Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисруудын ордон Индекс: 10018
Цахим шууданд: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)

ХАНДИВЫН ДАНС
ХААН БАНК: 5073035840
ГОЛОМТ БАНК: 4305125348
Данс эзэмшигч: Ээж-Сэргэлэн Ганзаяа
Харилцах утас С.Ганзаяа 88376062